Яаралтай тусламжийн тогтолцоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чухал бүрэлдүүн хэсэг болох нь

Л.Ганболд[1]

[1]АШУҮИС, АУС, Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим
Цахим шуудан: ganbold@mnums.edu.mn, Утас:99145624

Удиртгал: Яаралтай тусламж гэдэг нь цочмог өвчин эмгэг, осол гэмтлийн үед хугацаа алдалгүй яаравчлан тусламж үзүүлэх үйл ажиллагааны цогц талбар мөн.[1]

"Өвчөлийн даяршлалыг чухалчлахуй" нэвтэрхий тол бичэгт (9-р ботид) дурдаснаар Бага, дунд орлогтой улс орнуудад тохиолдох нийт нас баралтын тэн хагасаас илүү хувь буюу 45 сая хүн нас барсны 24 сая нь эмнэлэг хүртлэх болон эмнэлгийн яаралтай тусламжийн шатлалд тохиолдож буй хэмээн дурджээ. Энэхүү эмгэнэл, эндэгдлийг бууруулах нэг үндэс нь яаралтай тусламжийг тууштай хөгжүүлэх, тухайн тогтолцоог батжуулах, бэхжүүлэхэд оршино.[2]

Дэлхий дахинаа өдөр тутам цочмог өвчин эмгэгээр өвдсөн, осол гэмтэлд өртсөний улмаас яаралтай тусламж шаардлагатай болсон хүмүүс олон мянгаар тоологдно. Цочмог өвчин эмгэг, осол гэмтэл нь хаа сайгүй тохиолдоно, тэдгээр иргэд эмнэлгийн тусламж авахын тулд түргэн тусламжийн машин, такси, хувийн унаа, мотоцикл хийгээд зарим улс оронд ердийн хөсөг, ундаг дугуй, явганаар ирэх нь ч элбэг. Тэдэнд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд хэрэгцээтэй өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, хүний нөөц бүрэлдсэн байх эсэх нь эргэлзээтэй. Гэхдээ тухайн орон нутагт яаралтай тусламжийн тогтолцоо байх эсэхээс үл хамааран өдөр тутам их хэмжээний нөөц, хүчийг энэ салбарт зарцуулдаг юм.[2]

Эмнэлгийн яаралтай тусламж хийгээд тогтолцооны тодорхойлолтын тухайд: Эмнэлгийн яаралтай тусламж гэдэг нь тухайн тохиолдлын эмнэлзүй, эмгэг жамын онцлогоос хамааран цөөн хором, богино хугацаанд яаравчлан хэрэгжүүлэх шаардлагатай эмнэлгийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багц арга хэмжээ бөгөөд энэ нь үйлчлүүлэгчийн амь насын авран хамгаалах, аливаа хүндрэл, урхагаас сэргийлэх зорилготой. [3, 4]

Дээрх тохиолдлуудад эмнэлгийн яаралтай тусламжийн шуурхай хүргэхгүй бол нас баралт, эрхтэн тогтолцооны эргэшгүй алдагдалд хүргэх нигууртай. Яаралтай тусламжийн онцлогийг тодорхойлох олон үзүүлэлт байна. Үүнд:


- Тусламж үзүүлэх хугацаа яаравчлалтай
- Эмнэлзүйн хийгээд амин үзүүлэлтүүд огцом алдагдалтай
- Амь насыг аврах, эрхтэн тогтолцооны эргэшгүй алдагдлаас хамгаалах нэн яаралтай ажилбар, аргачлалуудыг хэрэгжүүлэх заалттай байх зэрэг болно.

Жишээлбэл: Шокийн байдалтай эсвэл амьсгалын гүн дутагдалтай өвчтөнд яаравчлан тусламж үзүүлэхгүй бол тавилан муудаж, амь нас эрсдэх аюултай, харин халдвар, багтрааны сэдрэл, шархны халдвар зэргийг үед хугацаа алдсан тохиолдолд цаашидын эмчилгээний үр дүн, нөлөө тавилан зэрэг нь эрс буурна. Ялангуяа эмнэлгийн тусламж авахад саад бэрхшээл ихтэй, хүрэлцээ хүртээмж муутай тохиололд хүмүүс зөвхөн цочмог өвчин эмгэг, осол гэмтэлд нэрвэгдсэн тохиолдолд л эмнэлэгт ханддаг байна.

Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоо гэдэг нь аливаа цочмог өвчин эмгэг, осол гэмтлийн үед яаравчлан эрэмблэх, аминд халтай эмгэгийг хугацаа алдалгүй илрүүлэх, амин үйлийг зүгшрүүлэх, яаралтай хийгээд ажилбарт тусламжийг үзүүлэх, цаашид шаараглагатай тээвэрлэлтийг осол хүндрэлгүй хэрэгжүүлэх зэрэг анхан шатлалын бүтцэд хамаарах эмнэлгийн тусламж үйлчилгээний салбарыг нэрэлнэ. Эмнэлгийн яаралтай тусламжийн дээрх тогтолцоо нь халдварт болон халдварт бус цочмог өвчин эмгэг, осол гэмтэл, жирэмсэн эх, төрөлтийн хүндрэл зэрэг амь тэнссэн бүхий л тохиолдлыг хамран үйлчилнэ. Энэ тогтолцоо нь дуудлагын талбарт үзүүлэх тусламжаас эхлэн, тээвэрлэлт, яаралтай тусламжийн тасаг, хэсэг цаашид амь тэнссэн төлөвт үзүүлэх тусламж, шаардлагатай тохиолдолд мэс заслын яаралтай хагалгаа хийх, эрчимт эмчилгээг хэрэгжүүлэх зэрэг тусламж үйлчилгээний гинжин хэлхээ, түүнд шаардагдах бүтэц бүрэлдэхүүнтэй байна.[10]

Эмнэлгийн яаралтай тусламжийг тууштай хөгжүүлэх, нэн шаардлагатай, зайлшгүй суурь тусламжийг эмчилгээ үйлчилгээний бүх шатлалд цаг алдалгүй үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх нь тухайн улс орны эрүүл мэндийн тогтолцооны нэн чухал зорилгын нэг байдаг бөгөөд цочмог өвчин эмгэг, осол гэмтлийн улмаас учрах хүндрэл, нас баралтыг бууруулах түлхүүр арга хэмжээ болно.

Яаралтай тусламжийн бүрэлдүүн хэсгүүд: ДЭМБ нь Яаралтай тусламжийн тогтолцоонд харьяалагдах бүтцийг тодорхойлсон: дуудлагын талбарт үзүүлэх тусламж, эмнэлэг хүртлэх тээвэрлэлт, эмнэлгийн шатлалд яаралтай тусламжийн тасаг, хэсэгт үзүүлэх тусламж, шаардлагатай тохиолдолд мэс заслын, эрчимт эмчилгээний тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэх зэрэг бүрэлдүүн хэсгүүд байна Зураг 1.[4]



Зураг 1. Яаралтай тусламжийн бүрэлдэхүүн хэсгүүд нь: дуудлагын талбарт үзүүлэх тусламж, эмнэлэг хүртлэх тээвэрлэлт, эмнэлгийн шатлалд яаралтай тусламжийн тасаг, хэсэгт үзүүлэх тусламж, шаардлагатай тохиолдолд мэс заслын, эрчимт эмчилгээний тусламжийн хугацаа алдалгүй үзүүлэх зэрэг бүрэлдүүн хэсгүүд байна.



Зураг 2. Яаралтай тусламжийн мэргэжлийн тусламж авахаар хандагсад түргэн тусламжийн эмч-ажилтанууд, сум, өрхийн эмчид очих, эсвэл лавалгаа шатлалын эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн зорин ирж үйлчүүлэх боломжтой.

Цочмог өвчин эмнэгийн улмаас эмнэлэгт хандагсад тусламж үйлчилгээний бүх шатлалын яаралтай тусламжийн тасаг хэсгүүдэд ханддаг байна. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж буй нэгж, хэсгүүдийг эмнэлэг хүртлэх шатлалын (түргэн тусламж), эмнэлгийн анхан шатлалын (сумын эмнэлэг, өрхийн эмнэлгийн), II, III шатлалын эмнэлгийн яаралтай тусламж хэмээн зэрэглэн үзнэ. Яаралтай тусламжийн мэргэжлийн тусламж авахаар хандагсад түргэн тусламжийн эмч-ажилтанууд, сум, өрхийн эмчид очих, эсвэл лавалгаа шатлалын эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн зорин ирж үйлчүүлэх зэрэг шатлал тус бүрийн яаралтай тусламжийн бүрэлдүүн хэсэгт очиж тусламжийг хүртэх боломжтой (зураг 2).[5] Нэгдсэн эмнэлгүүд, мэргэшлийн тусламж үзүүлдэг эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг нь өөрийн харьяалалын түргэн тусламжийн нэгжтэй, амилуулах-эрчимт эмчилгээ хийх тусгай хэсэгтэй, яаралтай хагалгааны өрөөтэй болон хөгжсөн байна. Яаралтай тусламж үзүүлэх бүрэлдүүн хэсгийн үйл

ажиллагааг улс орон бүрт өөрийн орны онцлогт тохируулан зохион байгуулж байна.

Олон улсын хамтын нийгэмлэг болон ДЭМБ-аас Яаралтай тусламжийг хөгжүүлэх талаар гаргасан бодлогын баримт бичгүүд: Олон улсын хамтын нийгэмлэг болон ДЭМБ нь амь тэнссэн үеийн анагаах ухаан судлал, яаралтай тусламжийн тогтолцооны хөгжлийн талаар удаа дараа хэлэлцэн чухал шийдвэрүүдийг гаргасаар ирсэн билээ. Үүний тод жишээ нь тухайн асуудлаар Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблей(их хуралдай)-н олон удаагийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох бодлогын баримт бичгийг батлан гаргаж байсныг дурдаж болно. Үүнд: Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн 2007 оны 05 сарын 23-ны 60 дугаар хуралдаанаар “Helath systems: emergency care systems” хэмээх сэдвээр хэлэлцэж “Эмнэлэг хүртлэх хийгээд эмнэлгийн шатлалын яаралтай тусламжийг цогц хэлбэрээр зохион байгуулж, дээрх хоёр шатлалын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, үр дүнгий нь үнэлэхийг гишүүн орнууд болон ДЭМБ-д үүрэг болгосон байна.[6]

Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн 2015 оны 05 сарын 26-ны 68 дугаар хуралдаанаар “Strengthening emergency and essential surgical care and anaesthesia as a component of universal health coverage” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж Эрүүл мэндийн анхан шатлалын эмнэлгүүдэд яаралтай болон мэс засал, мэдээгүйжүүлгийн суурь тусламжийг тухайн орон нутгийн эмчилгээ үйлчилгээний чухалчлах чиглэл болгон зохион байгуулахыг гишүүн орнуудад үүрэг болгожээ.[7] Энэ чиглэлээр манай оронд ч олон төрлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэний үр дүнд АШУУИС-ийн дэргэд ДЭМБ-ийн олон улсын зохицуулах төв байгуулагдаж “Мэс засал, мэдээгүйжүүлгийн тусламжийг чадвахжуулах, хөдөөгийн мэс заслыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр-MOG-01” төслийг амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн дараагийн буюу 2016 оны 05 сарын 28-ны 69 дугаар хуралдаанаар “Addressing the challenges of the UN Decade of Actions for Road Safety” сэдвээр хэлэлцэж “Гишүүн орнуудад эмнэлэг хүртлэх яаралтай тусламжийн тогтолцоогоог улам чадвахжуулах, яаралтай тусламжийн үндэсний сургалтын програмыг батлуулан хэрэгжүүлэхийг үүрэг болгох” тухай шийдвэр гаргажээ. Энэ дагуу ДЭМБ-ийн боловсруулан гаргасан “Яаралтай тусламжийн үндэс” сургалтын хөтөлбөрийн дагуу олон улс орон түүний дотор Монгол Улсын сургалтын холбогдох байгууллагууд сургалт, судалгааг зохион байгуулан ажиллаж байна.[8]

Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн 2019 оны 05 сарын 28-ны 72 дугаар хуралдаан нь Яаралтай тусламжийн хөгжлийн бодлого, цаашдын хөгжлийн талаар улс орон бүрт чухал ач холбогдолтой үйл явдал болсон.[9] Дээрх хуралдаанаар “Emergency care systems for universal health coverage: ensuring timely care for the acutely ill and injured” гэсэн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж тухайн салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн тухай олон чухал шийдвэрүүдийг гаргажээ. Энэхүү хуралдаанаар яаралтай тусламж нь бүх нийтийн эрүүл мэндийн төгс тусламжийг хэн бүхний амийг аврахуйц, хугацаа алдахгүй, тэгш хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлэх тогтолцооны нэн чухал бүрэлдүүн хэсэг болох тул тухайн салбарыг тогтвортой хөгжүүлэх, түүнд шаардагдах санхүүжилтийг тууштай дэмжих бодлогыг баримтлан ажиллахыг гишүүн орнуудад үүрэг болгосон байна.

ДЭМБ-ын 13 дугаар Нэгдсэн Хөтөлбөр нь дэлхий дахинхаа яаралтай тусламжийг чадвахжуулах, олон төрөл мэргэжлийн үйл ажиллагааны цогц нэгдэл хэлбэрээр 2019-2023 онуудад цаашид хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.[10] Энэхүү зорилтны хүрээнд дэлхийг олон орны эрдэмтэд, эмч нар өөрийн орны яаралтай тусламжийн салбар, тогтолцооны хөгжлийн өнөөгийн шаардлаганд хүртэл хөгжүүлэх, дээрх тусламжийн хүртээмжийн нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах талаар дээрх хуралдаанаас боловсруулан гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.

“Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд” хэмээх Тогтвортой хөгжлийн зорилго: Хүн бүр хэрэгцээтэй үедээ эрүүл мэндийн чанартай, эрсдэл аюулгүй, шуурхай үйлчилгээг санхүүгийн аливаа бэрхшээл, дарамтгүйгээр хүртэх боломжоор төгс хангагдсан байх нь хүний үндсэн эрх мөн.

“Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд” хэмээх зорилго нь хүн бүр эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээг (өвчнөөс сэргийлэх, эмчлүүлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх тусламж зэрэг) санхүүгийн элдэв бэрхшээлгүй, төлбөрийн хөнгөлөлтэйгээр авах бололцоог бүрдүүлэхэд оршино[11].

Олон улсын хамтын нийгэмлэг буюу НҮБ, ДЭМБ-аас “Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд” (Universal Health Coverage) хэмээх зорилгыг дэвшүүлэн дэлхий дахинаа 2030 он хүртэл хэрэгжүүлэх баримт бичгийг боловсруулжээ.

Дэлхийн олон улс орны аль ч буланд иргэд нь яаралтай тусламжийг хугацаа алдалгүй авах бололцоотой, тухайн тусламжийг үзүүлэх эмнэлгийн байгууллага, хүний нөөц нь хүртээмжтэй, аливаа төлбөр хураамжаас хол хөндий, чанарын өндөр түвшинд үзүүлдэг байхад дээрх зорилт оршино. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд харилцан шүтэлцээтэй 3 хүчин зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Иргэдийн шаардлаганд нийцэх эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх
- Эрүүл мэндийн тусламж авахад санхүүгийн хамгаалалтыг хэрэгжүүлж, төлбөрийн дэмжлэг үзүүлэх
- Эрүү мэндийн тусламж үйлчилгээнд хүн амыг тэгш хамруулж хүртээмжийг нэмэгдүүлэх

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай, хямд өрттөгтэй тусламжийг хэрэгцээтэй үед нь санхүүгийн элдэв бэрхшээл саадгүй, аюул эрсдэлгүй үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх, даяршуулах үйл ажиллагааг онцгойлон авч үзсэн байна. Тиймээс яаралтай тусламжийн тогтолцоо нь “Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд”

хэмээх зорилгын нэн чухал салашгүй бүрэлдхүүн хэсэг бөгөөд дээрх зорилгыг хангахад амин чухал үүрэгтэй.

Дэлхий даяр иргэд, цочмог эмгэг, осол гэмтэлд өртөгсөдийн эмнэлгийн тусламж авах анхны цэг, эмч-үйлчлүүлэгчийн уулзалтын гарааны шугам нь яаралтай тусламжийн нэгж, хэсгүүд байх тул тухайн эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээний өнгө төрхийг тодорхойлох чухал салбар мөн.

Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог ямар учраас хөгжүүлэх шаардлагатай вэ? Дэлхий дахинаа дэвшүүлэн тавьж хэрэгжүүлэх шатандаа яваа "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-ад нийт 17 зүйл зорилго хамаарагдахаас 3 дугаар зүйл нь "Хүний эрүүл мэнд сайн сайхан байдлын хангахын төлөө" гэсэн уриан дор хэрэгжиж байдаг ажээ. Энэхүү 3-р зорилт өөртөө 9 дэд зорилтыг агуулдаг бөгөөд ТХЗ-ийн эдгээр зорилт тус бүрийг хэрэгжүүлэх үйл хэрэгт яаралтай тусламжийн тогтолцооны үүрэг, үйл ажиллагаа шууд хамааралтай, нэн чухал үүргийг гүйцэтгэнэ гэдгийг хүснэгт 1-д үзүүлэв. [11] Тиймээс эрүүл мэндийн салбарын Эмнэлгийн яаралтай тусламжийг дэмжин хөгжүүлнэ гэдэг нь дэлхий дахины тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд бидний оруулж буй үнэт хувь нэмэр юм хэмээн ойлгож болно.

Хүснэгт 1. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд яаралтай тусламжийн тогтолцооны үүрэг оролцоо

Зорилтууд (дугаарын дагуу)	Эрүүл мэндийн салбарт 2030 онд хүрэх тогвортой хөгжлийн дэвшүүлсэн зорилтууд	Тогвортой хөгжлийн зорилтууд яаралтай тусламжийн хэрэгжүүлэлттэй холбогдох нь
3.1	100,000 амьд төрөлтөнд тохиолдох эхийн нас баралтыг (<70) буруулах, хөгжингүй орнуудад тэглэх	Эх барихын яаралтай тусламжийг (цус алдалт, манас таталт, даралт ихдэлт, үжил) цаашид чадвахжуулах, хүний нөөцийг сайжруулах
3.2	1,000 амьд төрөлтөнд нярайн нас баралтыг 12 хийгээд 5 хүртлэх насны хүүхдийн нас баралтыг 25 хүртэл бууруулах	Хүүхдэд тохиох цочмог өвчин эмгэгүүд тухайлбал уушгины хатгаа, гүйлгэлт суулгалтыг эмчлэн эдгэрүүлэх бололцоог дээшлүүлэх
3.3	ДОХ, сүрьеэ, хумхаа хийгээд гепатит, ус, агаар-дуслын замаар халдварладаг өвчин эмгэгийг хазаарлан зогсоох, устгах	Цочмог халдварт өвчний хүндрэл, халдвар-үжлийн эрт оншилгоо, эмчилгээг чухалчлан үзэх, шинэлэг арга аргачлалуудыг нэвтрүүлэх
3.4	Халдварт бус өвчин эмгэгээс сэргийлэх, эмчилэн эдгэрүүлэх, сэтгэл зүйн хийгээд амьдрахуйн нөхцлийг дэмжих замаар цагаасаа эрт нас барахыг гуравны нэгээр (1/3) бууруулах	Халдварт бус архаг өвчин эмгэгийн (NCDs) сэдрэл (зүрхний шигдээс, цус харвах, астма), хүндрэлийн тусламжийг чанаржуулах, эмчлэн эдгэрүүлэх салбар анагаах ухаан судлалыг хөгжүүлэх
3.5	Архаг архидалт, донтолт, тамхидалт зэрэг хорт зуршилд автахаас сэргийлэх, донтолтыг хязгаарлан зогсоох үйл ажиллагааг улам эрчимжүүлэх	Хорт зуршилд донтогсод, өндөр тунгаар хордож амь нас нь аюулд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, амь насыг аврах
3.6	Дэлхий дахинд зам тээврийн гэмтлийн улмаас нас барах тохиолдлыг 50%-иар бууруулна	Зам тээврийн гэмтэлд нэрвэгдэгсдэд үзүүлэх яаралтай тусламжийг чадвахжуулах, дэд бүтэц-хүний нөөцийг нэмэгдүүлэх
3.8	"Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд" хэмээх зорилго нь хүн бүр эмнэлгийн шаардлагатай тусламж үйлчилгээг (өвчнөөс сэргийлэх, эмчлүүлэх, төлбөрийн дэмжлэг авах, нөхөн сэргээх, хөнгөвчлөх зэрэг) санхүүгийн элдэв бэрхшээлгүйгээр авах	Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг хэн бүхний амийг аврахуйц, хугацаа алдахгүй, тэгш хүртээмжтэй хүргэх боломжтой яаралтай тусламжийн тогтолцоог бүрдүүлэх
3.9	Хорт хий, химийн бодис, агаар , ус, хөрсний бохирдлын улмаас үүсэх нас баралтыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах	Хүрээлэн байх орчны сөрөг нөлөөлөл, хорт бодисоос үүдэлтэй эмгэгт үзүүлэх тусламжийг сайжруулах
11.5	Гамшгийн улмаас учрах нас баралтыг бууруулах, эдийн засгийн алдагдлаас үүдэн гарах эрүүл мэндэд тулгамддаг асуудлууд ялангуяа ядуучууд хийгээд өртөмтгий бүлгийн иргэдийг хамгаалах	Гамшгийн бэлэн байдал, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, нэрвэгдсдийн эрүүл мэндийг хамгаалах "цайзан" тогтолцоог цаашид хүчирхэгжүүлэх
16.1	Хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, хүчирхийллээс үүсэх нас баралтыг бууруулах	Осол гэмтэл, хүчирхийлэлд нэрвэгдэгсдийн эмнэлгийн яаралтай тусламжийг чадвахжуулах, эмчилэн эдгэрүүлэх

Аливаа өвчин эмгэгийн эмнэлзүй, эмгэг жамыг үндэслэн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг өндөр технолог ашиглан хэрэгжүүлж өвчтөний амь насыг аварч хамгаалах бололцоо нэгэнт бүрдсэн орчин цагт бид амьдарч байна. Харин дээрх тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэх бололцоог хангах эсэх нь яаралтай тусламжийн эмч, дээрх эмгэгийг илрүүлж, яаравчлан арга хэмжээ авч хэрэгжүүлэх эсэхээс шууд хамаардаг байна. [12]

Яаралтай тусламжийн нэгжид ажилладаг эмч,

ажилтнууд нөөц бололцоо хязгаарлагдмал нөхцөлд эмнэлзүйн үзлэг, үнэлгээ хийж урдчилсан дүгнэлтийг гарган шаардлагатай суурь тусламжийг үзүүлнэ. Эмнэлт суурилсан яаралтай тусламжийн нэгжийг зохион байгуулан ажилласнаар цочмог эмгэг, осол гэмтэлд нэрэвэгдэгсдийг яаравчлан эрэмблэж, амь насанд халтай эмгэг өөрчлөлтийг хугацаа алдалгүй илрүүлэн, шаардагдах суурь тусламжийг шуурхай үзүүлснээр цагаасаа эрт нас барах тохиолдлыг мэдэгдэхүйц бууруулж, эртэн тогтолцооны эргэшгүй өөрчлөлт, хүндрэл үүсэхээс сэргийлэх өндөр ач холбогдолтой. Энэ төрлийн тогтолцоог байгуулсны дүнд уушигны хатгаа, үжил зэрэг өвчний улмаас учрах нас баралтыг гуравны нэгээр, гэмтэл ослын улмаас нас баралтыг 50%-иар бууруулсан дүн гарчээ. [12,13]

Зүрхний шигдээсийг эрт илрүүлж 60 минутын хугацаанд мэргэшлийн яаралтай тусламж үзүүлсний дүнд нас баралтыг 2 дахин, цус алдалт, манас таталт, ужил зэрэг төрөлтийн үед тохиолдох хүндэрлүүдийг эрчимтэй эмчилснээр эхийн нас баралтыг 50% бууруулдаг болохыг судлаачид олж тогтоожээ.[14, 15]

Бага, дунд орлогтой улс орнуудад тохиолдох цочмог эмгэг, гэмтэл ослын үеийн эмнэлэг хүртлэх болон эмнэлэгт суурилсан яаралтай тусламжийг сайтар хөгжүүлсэн нөхцөлд нас баралтыг 54% бууруулах боломжтой хэмээн үздэг.[17,18]

Яаралтай тусламжид тулгамддаг асуудлууд: Яаралтай тусламжийн салбарт мөрдөгдөх удирдамж, дэслэл (протокол), стандартыг боловсруулах өөрийн орны практик үйл ажиллагаанд нэвтүүлэх, тухайн удирдамжийг ханган ажиллах дэд бүтэц, хүний нөөцийг бүрдүүлэх нь тухайн тогтолцооны өмнө тулгарч буй тулгамдсан асуудлын нэг мөн.

Ямарваа эмнэлэгт тусламж авахаар ирэх үйлчлүүлэгчдийн ихэнх нь амь насанд аюултай шинж тэмдэг илэрч байх эсэхийг сайтар ялган ойлгохгүй зөвхөн яаралтай тусламжийн эмчид үзүүлье гэсэн сэдлээр ханддаг байна. Яаралтай тусламжийн тэргүүн эгнээнд ажиллаж буй хэн боловч юуны түрүүнд тухайн тохиолдолд амь насанд аюултай шинжүүд байгаа эсэх, хэрэв дээрш шинжүүд илэрсэн бол аврах тусламж үзүүлэх, амин үйл алдагдагдсан бол яаралтай эрэмбээр зүгшрүүлэх, эмнэлзүйн байдлыг сайжруулах заалттай ажилбар, аргачлалуудыг хэрэгжүүлэх, цаашид мэргэжлийн тусламж үзүүлэх тасаг, эмнэлгийн байгууллагт аюул осолгүй тээвэрлэн хүргэх үүргийг хүлээнэ. Яаралтай тусламж шаардагдах олон арван цочмог эмгэг өвчнүүд (гэмтэл осол, халдварын хүндрэл, төрөлтийн хүндрэлүүд, тархины харвалт, зүрхний шигдээс, амьсгалын дутагдал зэрэг) нь эрүүл мэндийн тогтолцооны урхагын (burden) тодорхой хэсгийг бүрдүүлнэ. [19, 20]

COVID-19 цар тахлын давалгаа нь яаралтай тусламжийн тогтолцооны хүрэлцээ, нөөцийг шалгаж шавхсан сорилт болов. Чухамдаа энэ цар тахлын үед яаралтай тусламжийн тогтолцоо нь анагаах ухааны чухал салбар хийгээд нийтийг хамарсан гамшиг ослын үед даван гарах түлхүүр хүчин гэдгийг нотлон харууллаа. Энэ үед яаралтай тусламжийн мэргэжил эзэмшсэн, тусламж үйлчилгээ үзүүлэх чадвартай эмч, сувилагчдын нөөц дутагдаж, бусад салбарын мэргэжилтнүүдийг дайчлан ажиллахад хүрсэн. Чухамхүү эрүү мэндийн тусламж үйлчилгээний тэргүүн шугманд ажилладагийн хувьд COVID-19-ийн халдварт өртсөн эсэх хийгээд халдвартай тохиолдолд яаравчлан эрэмблэх, халдвар хамгаалалтыг мөрдөн ажиллах, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх, оношт тодруулах, ажиглах өрөө, яаралтай болон эрчимт эмчилгээний тусламж үзүүлэх, амьсгалын дутагдал зэрэг амин үйлийг дэмжих, орлуулах олон төрлийн тусламжийг үзүүлж цар тахлын эсрэг тэмцэлд манлайлан оролцож өндөр үр дүнтэй салбар гэдгээ батлан харууллаа.

Яаралтай тусламжийн тогтолцоо нь “Эрүүл мэндийн төгөлдөр тусламжийг бүх нийтэд” зорилтын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд COVID-19 цар тахал болон бусад олныг хамарсан бусад төрлийн гамшиг, осол гэмтлийн үеийн тусламжийг үзүүлэх чухал салбар мөн.

Яаралтай тусламжийн тогтолцоонд цаашид дэвшүүлэх зорилтууд:

- Эмнэлгийн яаралтай тусламжийг цаашид хөгжүүлэх, бусад мэргэжлийн тусламж үйлчилгээтэй уялдуулан нэгдсэн цогц бодлого боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах
- Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцооны дэд бүтэц, хүний нөөц, эмчилгээ үйлчилгээний байдал зэрэг эмнэлзүй, зохион байгуулалтын үр дүн, үзүүлэлтийг судлах, бүртгэлжүүлэлтийг сайжруулах
- Яаралтай тусламжийн салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үр дүн зэргийг хамарсан судалгааны ажлыг өргөх хүрээтэй хэрэгжүүлэх, судалгааны ажлыг санхүүжүүлэх
- Яаралтай тусламжийн салбарт хэрэглэх удирдамж, протокол, хөтөчийн боловруулалтыг чанаржуулах, тугээлт, хэрэглээг сайжруулах
- Яаралтай тусламжийн тогтолцоог хөгжүүлэх, тогтвортой, өндөр үр дүнтэй ажиллахад шаардагдах санхүүгийн дэмжлэгэ үзүүлэх
- Анхан шатлалын эмнэлгийн яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах
- Эмнэлэг хүртлэх хийгээд эмнэлэгт түшиглэсэн яаралтай тусламжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн болон бусад салбарын үр дүнтэй хамтын ажиллагааг бүрдүүлэх
- Хөдөөгийн эмнэлгийн эмнэлэг хүртлэх болон эмнэлэгт түшиглэсэн яаралтай тусламжийг чадвахжуулах
- Яаралтай тусламжийн тогтолцоог дэмжсэн, ажиллагсдын үйл ажиллагааг урамшуулсан бодитой үнэлгээнд тулгуурласан даатгалын тогтолцоотой байх зэрэг болно.

Ном зүй:

1. *Emergency care systems for universal health coverage: ensuring timely care for the acutely ill and injured Report by the Director-General. https://apps.who.int/gb/ebwha/pdf_files/WHA72/A72_31-en.pdf*

2. DCP3 Volume 9_Ch 13 Emergency care .pdf (page 1of 19)
3. Kobusingye, Olive C. at all. Emergency medical systems in low- and middle-income countries: recommendations for action. Bulletin of the World Health Organization, 83 (8), 626 - 631. World Health Organization. https://apps.who.int/iris/handle/10665/269456
4. Hirshon JM, at all,. Health systems and services: the role of acute care.Bull World Health Organ. 2013 May 1;91(5):386-8. doi: 10.2471/BLT.12.112664. Epub2013 Jan 31. PubMed PMID: 23678202; PubMed Central PMCID: PMC3646345.
5. WHO Emergency care system framework,. http://www.who.int/emergencycare/emergencycare_infographic/en/.
6. WHA60.22 (2007) on health systems: emergency-care systems,
7. WHA68.15 (2015) on strengthening emergency and essential surgical care and anaesthesia as a component of universal health coverage, and
8. WHA69.1 (2016) on strengthening essential public health functions in support of the achievement of universal health coverage
9. https://www.who.int/news/item/27-05-2019-72nd-world-health-assembly-adopts-resolution-on-emergency-and-trauma-care
10. WHO's Thirteenth General Programme of Work, 2019–2023 to strengthen health systems, widen coverage of essential health services and improve integrated service delivery. Geneva: World Health Organization; 2018
11. https://www.who.int/health-topics/universal-health-coverage
12. Dare, A. J., J. S. Ng-Kamstra, J. Patra, S.H. Fu, P. S. Rodriguez, and others. 2015. "Deaths from Acute Abdominal Conditions and Geographical Access to Surgical Care in India: A Nationally Representative Spatial Analysis." The Lancet Global Health 3 (10): e646–e653.
13. Gaieski, D. F., M. E. Mikkelsen, R. A. Band, J. M. Pines, R. Massone, and others. 2010. "Impact of Time to Antibiotics on Survival in Patients with Severe Sepsis or Septic Shock in Whom Early Goal-Directed Therapy Was Initiated in the Emergency Department." Critical Care Medicine 38 (4): 1045–53.
14. Grimes, C. E., K. G. Bowman, C. M. Dodgion, and C. B. Lavy. 2011. "Systematic Review of Barriers to Surgical Care in Low-Income and Middle-Income Countries." World Journal of Surgery 35 (5): 941–50.
15. Hortmann, M., H. J. Heppner, S. Popp, T. Lad, and M. Christ. 2014. "Reduction of Mortality in Community-Acquired Pneumonia after Implementing Standardized Care Bundles in the Emergency Department." European Journal of Emergency Medicine 21 (6): 429–35.
16. Irfan, F. B., B. B. Irfan, and D. A. Spiegel. 2012. "Barriers to Accessing Surgical Care in Pakistan: Healthcare Barrier Model and Quantitative Systematic Review." Journal of Surgical Research 176 (1): 84–94.
17. Rivers, E., B. Nguyen, S. Havstad, J. Ressler, A. Muzzin, and others. 2001. "Early Goal-Directed Therapy in the Treatment of Severe Sepsis and Septic Shock," New England Journal of Medicine 8, no. 345 (19): 1368–77.
18. Terkelsen, C. J., J. T. Sørensen, M. Maeng, L. O. Jensen, H. H. Tilsted, and others. 2010. "System Delay and Mortality among Patients with STEMI Treated with Primary Percutaneous Coronary Intervention." Journal of the American Medical Association 304 (7): 763–71.
19. Sandercock, P. A., C. Counsell, M. C. Tseng, and E. Cecconi. 2014. "Oral Antiplatelet Therapy for Acute Ischaemic Stroke." Cochrane Database of Systematic Reviews 26 (3): CD000029.pub3.
20. Tim Baker, Essential Emergency and Critical Care: A Priority for Health Systems Globally. Crit Care Clin 38 (2022) 639–656 https://doi.org/10.1016/j.ccc.2022.06.008

Emergency care system is the imperative and invisible part of universal health coverage Being an essential part of the emergency system and health care

Ganbold L[1]

[1]*Department of Emergency Care and Anesthesiology, ASU, AUS*
E-mail: ganbold@mnums.edu.mn, Tel: +976-99145624

Introduction: All around the world, acutely ill and injured people of all ages seek care every day. Emergency care is an integrated platform to deliver time-sensitive health care services for acute illness and injury across the life course. The emergency care system that delivers these services extends from care at the scene through transport and emergency unit care, and it ensures access to early operative and critical care when needed.

Emergency care systems (ECSs) address a wide range of acute conditions, including injuries, communicable and non-communicable diseases, and complications of pregnancy. Especially when there are barriers to health care access, people may seek care only when acutely ill or injured. Emergency care is an essential component of universal health coverage—a critical mechanism for ensuring accessible, affordable, high-quality care—and for many people around the world, it is the primary point of access to the health system.

Emergency care (such as injuries, infections, obstetrical complica- tions, stroke, myocardial infarction, and respiratory failure) account for a substantial health burden. Improving the organization of and planning for emergency care services substantially improves the outcomes of patients with emergency conditions.

Summary: WHO ECS framework and the complementary essential package of emergency care services represent a mechanism by which emergency care can be scaled up globally, accelerating progress toward universal health coverage and a range of other SDG targets. By ensuring early recognition of acute conditions and timely access to needed care, organized emergency care systems save lives and amplify the impact of many other parts of the health system.

Keywords: Emergency care systems, diseases, health system

mindray
healthcare within reach

product design award 2018

BeneVision N1 Patient Monitor



Хяналтыг холбоно

Эмнэлгээс гадуур болон дотуур өвчтөнийг тээвэрлэх бүх төрлийн хэрэгцээнд зориулагдсан. BeneVision N1 нь олон талт, найдвартай шийдлийг санал болгож өвчтөнийг хянах төв удирдлагын системтэй хаанаас ч өгөгдлийг тасралтгүй хялбар байдлаар дамжуулан ажилладаг.

Зөөвөрлөлтийн найдвартай хамтрагч

Өвчтөнийг эмнэлгээс гадуур болон эмнэлэг дотор зөөвөрлөх явцын хамгийн найдвартай шийдэл



Жижиг хэмжээтэй
150x102x81мм

Маш хөнгөн
950гр

160°
Харах өнцөг
Аль ч өнцгөөс харж болно

Ашиглахад хялбар
Олон үйлдэлт, мэдрэгчтэй дэлгэцтэй

HD
HD Дэлгэц
5.5 инч 1280x720
нарийвчлалттай

Автомат дэлгэцний гэрэл
Эргэн тойрны гэрэлтүүлгээс
хамаарч дэлгэцийн гэрлийг автоматаар тохируулна














АЛБАН ЁСНЫ ОНЦГОЙ ЭРХТЭЙ ДИСТРИБЬЮТОР
БИОМЕД ТРЕЙД ХХК
504, UB Tower, 13 хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар 13374
+976-75052009

ЗҮРХИЙГ АВТОМАТААР СЭДЭЭГЧ ТӨХӨӨРӨМЖ

Гэнэтийн зүрх зогсолтын үед зүрхэнд автоматаар дүн шинжилгээ хийж шаардлагатай үед өндөр хүчдэлээр зүрхэнд сэдээлт өгснөөр өвчтөний амь насыг цаг алдахгүй яаралтай тусламж үзүүлэн аврах зориулалттай төхөөрөмж юм.

ЗАС төхөөрөмжийн онцлог:

- ✓ ЗАС буюу (AED, дефибриллятор) төхөөрөмжийн заавар, зурган тайлбар, дуут зааварчилгаа бүгд **монгол хэл** дээр орчуулагдсан
- ✓ Эмч болон жирийн иргэн ажиллуулах боломжтой
- ✓ Зүрхэнд цахилгаан сэдээлт өгөх шаардлагатай жирвэлзлэлийг 100% алдалгүй тогтоодог тул цахилгаан цохилтыг өөрөө бэлтгэж цохиулах шаардлагагүй
- ✓ Хоёр мөчлөгт буюу бүрэн алхамт
- ✓ 50-180 Жоулын хэмжээтэй цахилгаан энергиээр давтан цохиулж ховдлын жирвэлзлийг арилгах нь хүчдэлийг өсгөн нэмэгдүүлж цохиулдаг хагас алхамт гар удирдлагат дефибрилляторoос илүү үр дүнтэй.
- ✓ Тусламж үзүүлэх үеийг орчны аудио бичлэг хийж баримт бичиг болгон хадгалах боломжтой.
- ✓ Зүрхний хэмийг задлан шинжлэх бололцоотой.
- ✓ Тогонд залгах шаардлагагүй цэнэгээ өөрөө хянах ба 5 жил цэнэгээ барих батарей
- ✓ SD memory card болон USB холболтоор компьютертэй холбогдоно.
- ✓ Хэрэглэхэд ойлгомжтой энгийн үг хэллэгийг агуулсан.
- ✓ Нийт хүн амд таниулах зорилгоор ОУ-ын жишгийн дагуу өнгөний сонголтыг улбар шар өнгөөр тусгасан.
- ✓ Овор багатай.
- ✓ Тээвэрлэхэд хялбар, хөнгөн.
- ✓ Хүүхэд болон насанд хүрэгч гэсэн 2 горимд 1 пад буюу электрод ашигладаг давуу талтай
- ✓ Өөрийгөө шинэчлэх автомат горимтой

